

МАНДАЛ ДААТГАЛ ХК-НИЙ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Гүйцэтгэх захирлыг томилох тухай

Компанийн тухай хуулийн 76.1.8, 76.1.9 болон Компанийн дүрмийн 18.13.7, 8.13.8, 12.7-р заалт болон 2022 оны 08 сарын 04-ны өдрийн “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн ээлжит бус хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр 2022 оны 03 сарын 07-ны өдрөөс эхлэн ажиллаж байгаа Түмэннасан овогтой Батзулыг 2022 оны 08 сарын 04-ны өдрөөс эхлэн “Мандал Даатгал” ХК-ны гүйцэтгэх захирлын албан тушаалд томилсугай.

2. Хөдөлмөрийн тухай хууль болон Компанийн дүрэмд заасны дагуу “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирлаар томилогдсон Т.Батзултай хөдөлмөрийн гэрээг ТУЗ-ийн даргатай байгуулах ажлыг зохион байгуулахыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хууль болон журамд заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, Санхүүгийн зохицуулах хорооноос тохиромжтой этгээдийн талаар дүгнэлт гаргуулах, Гүйцэтгэх захирлаар томилогдсон талаар хамтран ажилладаг байгууллагуудад албан бичиг хүргүүлж, нийтэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулахыг “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирал Т.Батзулд даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшинд даалгасугай.

Энэхүү шийдвэрийг 2022 оны 08 сарын 04-ны өдөр бичгээр үйлдсэнийг гэрчлэн компанийн тухай хуулийн 80.2-р заалтыг үндэслэн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ